


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

10.05 - 10.09



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. АНУ-аас эдийн засгийг дэмжих нэмэлт хөтөлбөрүүд болон коронавирусын эмчилгээтэй холбоотой эерэг мэдээлэл гарсанаас үүдэн S&P 500 индекс сүүлийн 3 сарын хамгийн их өсөлтөө үзүүллээ. Мөн зах зээлийн үнэлгээ багатай Russell 2000 индекс 6%-аар өсөж, correction бүсээс гарсан байна.

ОРЕС-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Мохаммед Баркиндо үйлдвэрлэгчдийн хувьд "хамгийн хэцүү үе дууслаа" гэж мэдэгдсэн нь газрын тосны үнийн өсөлтөд нөлөөлснөөс эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байлаа. Харин видео тоглоом болон кабелийн утас үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш унасантай холбоотой харилцаа холбооны салбар хамгийн их уналттай байлаа.

Европ: АНУ-аас эдийн засгийг дэмжих хөтөлбөртэй холбоотой нааштай мэдээ гарсантай холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. STOXX Europe 600 индекс 2.11%-аар, Xetra DAX индекс 2.85%-аар, CAC 40 индекс 2.53%-аар, FTSE MIB индекс 2.79%-аар, FTSE 100 индекс 1.94%-аар тус тус өссөн байна.

Их Британийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 7-р сард 6.6%-аар өссөн байсан бол 8-р сард 2.1%-аар өссөн байна. 8-р сарын ДНБ-ий өсөлт нь Ройтерс агентлагийн явуулсан санал асуулгын дүнгээс хоёр дахин бага гарсан байна. Английн төв банкны ерөнхийлөгч ноён Эндрю Бэйли Европын Комиссоос зохион байгуулсан онлайн вебинар дээр, Их Британийн эдийн засгийн сэргэлт жигд бус байна, 3-р улирлын гарц нь COVID-19-ийн өмнөх түшин 7-10% доогуур байгаа бөгөөд эдийн засагт учрах эрсдэлүүд Их Британид коронавирусын халдвар нэмэгдэж байгаагийн улмаас "их сөрөг байна" гэж мэдэгджээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан байна. Nikkei 225 индекс 590 нэгжээр буюу 2.6%-аар өсөж 23,619.69 нэгж дээр хаагдсан нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 0.16%-ийн бууралт юм. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэх large-cap TOPIX болон TOPIX small индексүүд мөн их хэмжээний өсөлттэй хаагджээ.

Улирал тутам зохион байгуулдаг Япон улсын Төв банкны салбарын менежерүүдийн уулзалтад Төв банкны ерөнхийлөгч ноён Харухико Курода, Япон улсын эдийн засаг сэргэж эхэлж байгаа ба эдийн засгийг дэмжих сангийн болон мөнгөний бодлогын арга хэмжээ үр дүнтэй байсан мөн газрын тосны үнийн өсөлттэй холбоотой инфляцын хэмжээ өснө гэж таамаглаж байгаагаа илэрхийлжээ.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээл 10-р сарын 1-ээс 10-р сарын 8-ны өдрүүдийн хооронд амралтын өдөр таарсантай холбоотой хаалттай байсан ч Баасан гарагт өсөлт үзүүлжээ. Shanghai Composite A-share индекс 1.7%-аар, зах зээлийн үнэлгээ ихтэй CSI 300 индекс 2%-аар тус тус өссөн байна. Хятадын Ардын Банк нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан мөнгөний зах зээл дээрх хөрвөх чадварыг 560 тэрбум юаниар бууруулна гэсэнтэй холбоотой БНХАУ-ын 10 жилийн хугацаатай бондын хүү 4 нэгжээр өсөж 3.21% болов.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,601.52	0.07% ▲
Dow Jones	АНУ	28,586.90	3.27% ▲
S&P 500	АНУ	3,477.13	3.84% ▲
Nasdaq	АНУ	11,579.94	4.56% ▲
S&P/TSX	Канад	16,562.81	2.24% ▲
FTSE 100	Их Британи	6,016.65	1.94% ▲
S&P/ASX 200	Австрали	6,102.20	5.36% ▲
Nikkei 225	Япон	23,619.69	2.56% ▲
Hang Seng	Хонг Конг	24,119.13	2.81% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	4.46%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	4.08%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.88%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	2.08%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.11%
DBM' 2023	USD	7.250%	5.13%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	11.62%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	4.55%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.145	0.04 ▲
Libor 3M	0.224	-0.04 ▼
Libor 6M	0.246	0.00 ▲
Libor 1YR	0.348	-0.03 ▼
US 2YR Bond	0.153	0.19 ▲
US 3YR Bond	0.198	0.20 ▲
US 5YR Bond	0.337	0.19 ▲
US 10YR Bond	0.774	0.11 ▲

Валютын ханш	2020.10.09	Өөрчлөлт
USD	2,854.72	-0.01% ▼
CNY	425.09	1.11% ▲
EUR	3,362.15	0.46% ▲
RUB	37.01	1.59% ▲
KRW	2.49	1.63% ▲
JPY	26.95	-0.70% ▼
CAD	2,166.85	1.01% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,930.40	1.61% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	25.15	5.97% ▲
Зэс	USD/lb.	308.25	3.53% ▲
Нүүрс	USD/MT	58.50	-2.61% ▼
WTI газрын тос	USD/bbl.	40.60	9.58% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.85	9.12% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VIII	2.10%
Бодлогын хүү	2020.VIII	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VIII	8.73%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	10.84%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VIII	4.13%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	16.93%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VIII	10.44%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 460.5 сая төгрөгийн 1,783,122 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Талын гал” /MSE: TAL/ компанийн хувьцаа 14.99%-аар буюу хамгийн ихээр өсөж 18.25 төгрөг хүрч хаагдсан бол “Дархан хөвөн” /MSE: DAN/ компанийн хувьцаа 14.87%-аар буурч 5,950.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 54.9 сая төгрөгийн 549 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

10-р сарын 09-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,599.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,601.52 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.07% -аар өссөн байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	515.4
Зах зээлийн үнэлгээ	2,599,908.9

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,601.52	0.07% ▲
MSE I индекс	8,224.04	-0.36% ▼
MSE II индекс	7,486.89	-0.93% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	258,276	346,710,683
Ард кредит ББСБ	582,204	39,159,644
АПУ	48,100	27,143,786
Улсын их дэлгүүр	11,568	15,488,292
БиДиСек	11,808	10,041,060

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Талын гал	18.25	14.99% ▲
Дархан хүнс	2,940.00	14.84% ▲
Увс чацаргана	290.00	13.72% ▲
Монгол савхи	500.00	11.11% ▲
Монгол шуудан	598.00	6.07% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Дархан хөвөн	5,950.00	14.87% ▼
Монгол шевро	1,365.00	-14.68% ▼
Нийслэл өргөө	2,000.00	-13.04% ▼
Орхондалай	1,500.00	-11.76% ▼
Махимпекс	7,500.00	-11.71% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	789,549,176
БиДиСек	63,896,447
Алекс Капитал	28,246,412
Голомт Капитал	26,612,158
Бумбат-Алтай	23,354,208

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	569.00	605,519.30
Таван толгой	5,750.00	302,824.90
МИК холдинг	12,790.00	264,872.20
Инвескор ББСБ	2,850.00	204,424.57
Говь	194.00	151,341.83

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	549	54,899,860	99,990	101,000	52	17%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-нд ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-нд ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-нд ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-нд ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-нд ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-нд ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-нд ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-нд ОЛГОВ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний хувьчлалын сан” хамтын ХОС-гийн хүсэлтийн дагуу нэгж эрхийн анхдагч зах зээлийн худалдан авах захиалгын хуваарилалтын төлөвлөгөө, захиалга хүлээн авах нөхцөлд дараах өөрчлөлт орлоо. Үүнд:

- Стратегийн хөрөнгө оруулагчийн захиалгын доод, дээд хязгаарлалтыг хасах;
- 2020 оны 10-р сарын 15-ны өдөр орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан захиалга хүлээн авах эцсийн хугацааг 2020 оны 10-р сарын 16-ны 16 цаг болгон өөрчлөх.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN) ХК нь Баян Хөндий Төслийн талбайд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг огтолж, нөөцийг тэлэх боломжтойг харууллаа.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN) ХК нь Хөндий Алтны Дүүрэгт гүйцэтгэсэн 18,000 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийн анхан шатны үр дүнг танилцуулж байна.

Онцлох мэдээлэл:

Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд 10,000 метр бүхий 1-р үе шатны өрөмдлөгийг гүйцэтгэв:

- Баян Хөндийд 8,435 метрийн 4 өргөтгөлийн цооногийг хамарсан 45 цооног өрөмдсөн.
- Хар Морь талбайд 1,754 метрийн 11 цооног өрөмдсөн.

Баян Хөндийд өрөмдсөн 12 өргөтгөлийн цооног (2,016 метр)-ийн үр дүнгүүдэд:

- Хойд Мидфийлд: Төлөвлөсөн уурхайн хананаас зүүн болон баруун зүгт өргөтгөлийн өрөмдлөг гүйцэтгэн, өндөр агуулга бүхий эрдэсжсэн интервалыг огтолсон:
 1. BКD-302- Зүүн залгаа өргөтгөл: Цооногийн 127 метрийн гүнээс эхлэн (босоогоор 115 метр) 27.5 г/т алтны агуулга бүхий 2 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 22.4 метр интервалыг төлөвлөсөн уурхайн ханатай зүүн зүгт залгаа бүсэд огтолсон.
 2. BКD-304- Баруун залгаа өргөтгөл: Цооногийн 206 метрийн гүнээс эхлэн (босоогоор 144 метр) 38.9 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 12 метрийн интервалыг төлөвлөсөн уурхайн ханатай баруун зүгт залгаа бүсэд огтолсон.
- Баруун өмнөд Страйкер: Төлөвлөсөн уурхайн хананаас өмнөд зүгт өндөр агуулга бүхий эрдэсжсэн бүсийг тэлсэн:
 1. BКD-310- Цооногийн 14 метрийн гүнээс эхлэн 24.5

г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 4.0 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал, цооногийн 64 метрийн гүнээс эхлэн 16.2 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 1.0 г/т алтны агуулга бүхий 44 метрийн интервал огтолсон.

2. BКD-312- Цооногийн 13 метрийн гүнээс эхлэн 51.7 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 20.8 г/т алтны агуулгатай 3 метрийн интервал огтолсон.

Баруун өмнөд Мидфийлд, Баруун Страйкер, Зүүн хойд Баян Хөндий болон Хар Морь талбайд хийсэн 7,945 метрийн 48 цооногийн сорьцлолтын үр дүнгүүд хүлээгдэж байна.

- 10 цооногт нүдэнд үзэгдэх алт илэрсэн.

Эх сурвалж: Эрдэнэ ресурс девелопмент корпораци

“Хөнгөн бетон” /MSE: HBT/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр.

“Хөнгөн бетон” /MSE: HBT/ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 7-р сарын 22-ны өдрийн тогтоолын дагуу тус компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа 2020 оны 9-р сарын 16-ны өдөр хуралдуулахаар болсон билээ.

Тус хурлаар тухайн компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хэлэлцсэн бөгөөд “Хөнгөн бетон” /MSE: HBT/ ХК-ийн 2020 оны 9-р сарын 16-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор тус компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100%-ийн санаал баталсан байна.

2020 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаар тус компани нийт 179,373 ширхэг хувьцаа гаргаснаас 176,120 ширхэг буюу нийт гаргасан хувьцааны 98.12%-ийг 3 нөлөө бүхий хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бол үлдсэн 3,253 ширхэг буюу нийт гаргасан хувьцааны 1.81%-ийг 22 жижиг хөрөнгө оруулагчид эзэмшиж байгаа юм.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Ирэх онд Монгол Улсын эдийн засаг 8-9 хувиар өснө гэж Төв банк таамаглаж байгаагаа олон нийтэд танилцууллаа.

УИХ-аар хэлэлцэгдэж буй Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөлд ирэх онд инфляцыг +/- 2 нэгж хувийн интервалтайгаар зургаан хувийн орчимд тогтворжуулахаар зорьж байна. Мөн банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ гэжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Сангийн яам 2021 оны төсвийн төслийг Парламентад өргөн бариад байна. Үүнд уул уурхайн салбарын орлогыг харьцангуй өөдрөгөөр тусгаж өгчээ. Ирэх онд уул уурхайн салбарын орлого анх удаа 3.4 их наяд төгрөг хүрнэ гэж Сангийн яам тооцоолсон байна. Энэ нь төсвийн нийт орлогын 26 орчим хувийг бүрдүүлэх юм.

Гаалийн шинэчлэлийн хүрээнд хилийн боомтуудад ухаалаг гарц, лаборатори, өндөр хүчин чадлын рентген суурилуулж, хил нэвтрэх үйл ажиллагааг түргэн шуурхай, цахим болгоно гэж үзэж байна. Энэхүү ажил энэ онд нэлээд идэвхтэй хийгдэх хүлээлттэй байсан ч цар тахлын нөхцөл байдлаас болж удаашраад байгаа юм.

Мөн ашигт малтмалын экспортын үе шат бүрийг цахим төлбөрийн баримтын системд бүртгэж, татварыг нь бүрэн хураана гэж зорьж байна. "COVID-19" цар тахлын үед Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар нүүрсний экспортыг дэмжих

зорилгоор "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэ болон бусад гаалийн шинэчлэлийн үр дүнд ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолж, 1.3 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төсөөлж байна. Энэ онд мөн ийм төлөвлөгөө гаргасан ч тасалджээ. Оны эцэс гэхэд 25 сая тонн хүрнэ гэж УУХҮЯ үзэж байна.

Харин зэсийн тухайд тонн тутамдаа 6,500 ам.доллар байхаар төсөөлж, ирэх онд 1.4 сая тонн зэсийн баяжмал экспортолж, 1.5 их наяд төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцоолжээ.

Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 1.6 их наяд төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр Сангийн яам тооцоолж байна. Үүний 47.3%-ийг зэсийн баяжмал, 33.6%-ийг нүүрснээс, 11.3%-ийг алтнаас төвлөрүүлнэ гэж үзжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Гадаад худалдааны тэнцэл 2021-2023 онд дунджаар 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байгаа. Үүнд чулуун нүүрсний экспортоос гадна "Оюу толгой"-н зэсийн баяжмалын агууламж нэмэгдэхээр байгаа нь голлох нөлөөг үзүүлнэ гэж Сангийн яам тооцож байна. "Оюу толгой" компанийн хувьд энэ жилийн алтны гарцын төлөвлөгөө нэмсэн. 155-180 мянган унц алт, 140-170 мянган тонн зэс бүхий баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа. Үүнээс эхний хагас жилд 408.6 сая ам.долларын орлого олоод байгаа юм. "COVID-19"-ийн нөлөөгөөр өнгөрсөн хавар зэсийн ханш огцом унасан зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр борлуулалтын дүн нь өнгөрсөн оны мөн үеэс 44.4%-аар буурчээ. Монгол Улсад орж ирж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын 90 гаруй хувь буюу дийлэнхийг "Оюу толгой" төсөл дангаараа бүрдүүлдэг. Энэ жилийн тухайд "Оюу толгой"-н ил уурхайд 70-90 сая ам.доллар, гүний уурхайн бүтээн байгуулалтад 1-1.1

тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ гэдгээ хөрөнгө оруулагч тал зарласан. Гэхдээ цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж энэ дүнг оны эхэн үед танилцуулж байснаасаа бууруулсан юм. Монгол Улсын эдийн засгийн дунд хугацааны өсөлтөд ч бас "Оюу толгой" төсөл холбогдож байна. 2021-2023 онд өсөлтийг 6 орчим хувьд хүргэхээр зорьж буйгаа Сангийн яам төсвийн төсөлдөө тусгасан. Ингэхдээ мега төслүүдэд ихээхэн найдлага тавьж байгаагийн нэг нь "Оюу толгой"-н далд уурхай юм.

Гүний уурхай бүтээн байгуулалтаа дуусч, олборлолтоо эхлэх хугацаа хойшилж, нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон. "Rio Tinto" компанитай байгуулсан тохиролцооныхоо хүрээнд "Turquoise Hill Resources" компани 1.7-3.6 тэрбум долларын санхүүжилт бүрдүүлэх шаардлагатай болоод байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРЛИЙН СУДАЛГАА

Үнэт цаас эзэмшигчдийн бүтэц

2020 оны 9-р сарын 30-ны байдлаар Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвд бүртгэлтэй 317 компанийн нийт 14.4 тэрбум ширхэг үнэт цаасыг 354.3 мянган хөрөнгө оруулагчид эзэмшигч эзэмшиж байна.

Нийт хөрөнгө оруулагчдын 0.3% болох том хөрөнгө оруулагчид (5%-аас дээш хувь эзэмшиж буй) нийт үнэт цаасны 90.3%-ийг эзэмшиж байгаа бол жижиг хөрөнгө оруулагчид буюу нийт хөрөнгө оруулагчдын 99.7% нь нийт үнэт цаасны 9.7%-ийг эзэмшиж байна.

2020 оны 9-р сарын 30-ны байдлаар жижиг хөрөнгө оруулагчдийн эзэмшиж буй үнэт цаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Үнэт цаасны төвлөрөл

2020 оны 9-р сарын 30-ны байдлаар Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвд бүртгэлтэй 317 компанийн 111 нь 90-100 хүртэлх хувийн төвлөрөлтэй буюу 111 компанийн нийт гаргасан үнэт цаасны 90-100%-ийн том хөрөнгө оруулагчид эзэмшиж байна. Нийт бүртгэлтэй компаниудын төвлөрөл дунджаар 80.49%-ийн үзүүлэлттэй байна.


2020 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаар ҮЦТХТ-д бүртгэлтэй 100% төвлөрөлтэй 24 компани байгаагаас 21 нь төрийн өмчит компани байна.

Жижиг хөрөнгө оруулагчдын дийлэнх буюу 104,808 хөрөнгө оруулагч 70-80 хувийн төвлөрөлтэй компанийн үнэт цаасыг эзэмшиж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны төвлөрөл, 2020 оны 9-р сарын 30


Төвлөрөл /интервал/	Компанийн тоо	Нийт хөрөнгө оруулагчид	Том хөрөнгө оруулагчид	Жижиг хөрөнгө оруулагчид
0-10%	3	592	1	591
10-20%	2	742	3	739
20-30%	3	5,805	6	5,799
30-40%	5	10,941	14	10,927
40-50%	5	14,625	17	14,608
50-60%	19	15,770	47	15,723
60-70%	31	84,048	93	83,955
70-80%	50	104,808	183	104,625
80-90%	88	80,797	314	80,483
90-100%	111	36,125	332	35,793
100%	24	27	27	-
Нийт	317	354,253	1,010	353,243

Зураг 1. Хөрөнгө оруулагчдын бүтэц, 2020 оны 9-р сарын 30



Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Зураг 2. Үнэт цаасны төвлөрөл, 2020 оны 9-р сарын 30



Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.